

## МОНГОЛ, ОРОСЫН ХООРОНД НАЙРСАГ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

*О. Энхтөр\**

Зуун жилийн ойг нь энэ онд тэмдэглэж байгаа монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хувьсгалын үр дүнд Монгол орон хоёр зууны туршид үргэлжилсэн манжийн ноёрхлоос салсан билээ. Сэргэн мандсан Монголын төрийн тэргүүнээр Богд хаан өргөмжлөгдөв. Шинэ төрийн зүгээс Монголын ард түмэнд хандаж 1911 оны 12 дугаар сарын 1-ний өдөр гаргасан тунхаглалд “Манай Монгол анхнаасаа туурга тусгаар улс байсан бөгөөд энэхүү өнө эртний ёсыг даган” Монгол улс тусгаар улс болохыг тунхаглан зарлажээ.

Шашин, төрийг хослон барьсан хаант засаглалын хэлбэрээр сэргэн мандсан Монголын туурга тусгаар төр улсыг гадаад орнууд, нэн тэргүүнээ хөрш зэргэлдээ Орос, Хятад улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх талаар Богд хааны засгийн газар ихээхэн хүчин чармайлт тавьж байсан талаар бусад илтгэлүүдэд илүү тодорхой дурдах бизээ. Энэхүү багагүй хүчин чармайлтын нэг илрэл нь 1912 оны 11 дүгээр сарын 3-нд Нийслэл Хүрэнээ гарын үсэг зурсан Монгол-Оросын Хэлэлцээр байв. Тийнхүү хэлэлцээр байгуулж, нөлөө бүхий гүрэн Хаант Оростой олон улсын гэрээний харилцаанд орсон нь Монгол төрийн хувьд улс төрийн чухал ач холбогдолтой байлаа.

Хэлэлцээрийг байгуулахын өмнө тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх гадаад бодлогын чиг шугамыг хэрэгжүүлэх, Дотоод Монгол, Барга, Урианхайн хязгаар зэрэг монгол үндэстнүүдийн нутгийг Монгол улсын бүрэлдэхүүн хэсэг болгон нэгтгэх хэмээн Монголын ноёд нэлээд хүчин чармайлт тавьж байв. Энэхүү хэлэлцээрт Монгол улсын тусгаар байдлыг хоёр бичвэрт өөр өөрийнхөөр, тухайлбал монгол бичвэрт “тусгаар тогтносон”, орос бичвэрт “өөртөө засах” /автономит/ хэмээн тэмдэглэсэн нь анхаарал татна. Товч дүгнэхэд, энэхүү хэлэлцээр болон Монгол дахь оросын харьяат нарын эрхийг тусгасан хавсралт Протокол нь Монгол дахь Хаант Оросын давамгайллыг нотлон илэрхийлсэн баримт бичиг болжээ. Их гүрний бодлого, зорилгоо гүйцэлдүүлэх Оросын сонирхол нь тусгаар Монгол улс оршин байгааг де-факто хүлээн зөвшөөрч олон улсын гэрээт харилцаанд хамтран оролцсоноороо үйл явцын цаашдын таатай өрнөлд дэм болсон юм.

Богдын засгийн газар үүний зэрэгцээ АНУ, Англи, Бельги, Герман, Франц, Япон зэрэг бусад улстай ч харилцаа тогтоох замаар байр сууриа бэхжүүлэх боломжийг эрэлхийлж байлаа. Гадаад хэргийн сайд Ханддорж АНУ-ын Төрийн департаментад хандсан захиандаа /1912 он/ “тусгаар

\* О.Энхтөр - ГХЯ-ны Хөрш орнуудын газрын захирал

тогтносон бүрэн эрхт” Монгол улс байгуулагдсаныг мэдэгдэхийн хамт “худалдааны хийгээд найрсаг харилцааны гэрээ” байгуулахыг санал болгожээ. Гэвч Богдын засгийн газрын зүгээс хандсан дэлхийн гол гүрнүүд монголын талын хүсэлтийг ойшоосонгүй бөлгөө. Ийм нөхцөл байдал Гадаад Монголын нэлээд өргөн эрх бүхий автономийг хүлээн зөвшөөрсөн Орос, Хятадын хэлэлцээрийг 1913 оны 11 дүгээр сарын 5-нд байгуулсан байна. Богдын засгийн газар эдийн засгийн асуудлаар гадаад орнуудтай хэлэлцэн тохирч болох бөгөөд харин улс төрийн асуудлаар яриа хэлэлцээ явуулж болохгүй хэмээн эл хэлэлцээрт заажээ. Монголын төрт улсын хувь заяаг монголчуудын оролцоогүйгээр чингэж “шийдсэн” явдалд манай засгийн газрын зүгээс дургүйцлээ илэрхийлж, Нийслэл Хүрээн дэх Оросын консулын төлөөлөгчид нот гардуулсан байдаг.

Хиагтад 1914 оны намраас 1915 оны зун хуралдсан Монгол, Хятад, Орос гурван улсын бага хурал манай төр, улсын түүхэнд онцлог байр суурьтай. Монгол улсын бүрэн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхийг эрмэлзсэн монголын төлөөлөгчид эцсийн эцэст өөртөө засах /автономит/ байгууллыг аргагүй хүлээн авахад хүрсэн юм. 1915 оны 25-ны өдөр гарын үсэг зурсан Хиагтын гурван талын хэлэлцээр Монгол улсын олон улсын эрх зүйн байр суурийг “Автономит Гадаад Монгол” хэмээн тодорхойлжээ. Төр улсын энэхүү хэлбэр удаан оршин тогтнож чадаагүй бөгөөд 1919 онд Хятадын цэргийн эрхтнүүдийн түрэмгийллийн дүнд мөхсөн билээ. Өөртөө засах байгуулал нь улс орны тусгаар тогтнолын байр сууринаас аргагүйдэн хийсэн түр ухралт байлаа. Үүний сацуу Монголын тусгаар тогтнолыг хангах, олон улсын зүгээс хүлээн зөвшөөрүүлэх талаар Богд хаант засгийн газраас тавьж байсан идэвхтэй хүчин чармайлтыг нэн хүндэтгэн үзэх учиртай.

1921 онд ялсан Монгол ардын хувьсгал Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцлийн шинэ үе шатыг нээв. 1921 оны 9 дүгээр сард ардын засгийн газраас бусад улс, орнуудад хандан мэдэгдэл гаргаж, ардын эрхт тусгаар улс байгуулсныг зарлан тунхаглаж, тэдгээр оронтой эрх тэгш харилцах, худалдаа хийх хүсэлтэй буйгаа илэрхийлжээ. Монголын ард түмний бүрэн эрхэд харшилсан, тулган хүлээлгэсэн тэгш бус бүхий л гэрээ, хэлэлцээрүүд, түүний дотор 1915 оны Хиагтын хэлэлцээр хүчингүй болохыг мөн мэдэгдсэн байна. 1924 оны 11 дүгээр сарын 26-нд тунхагласан БНМАУ олон улсын эрх зүйн үүднээс бүрэн эрхт тусгаар тогтносон улсын бүхий л шинж төрхөд нийцсэн байв. Гэвч тэр үеийн гол гүрнүүд Монголын тусгаар тогтнолыг үл хүлээн зөвшөөрснөөрөө Хятадын зүгээс тавьж байсан зүй бус өнгөлзлөгүүдэд үнэн хэрэгтээ дэмжлэг өгч байлаа. Тэдгээр гүрнүүдийн ийм бодлого 1921-1922 оны Вашингтоны бага хурлын үеэр гарын үсэг зурсан есөн гүрний гэрээнд тусгалаа олсон байдаг.

Зөвлөлт улс дорно зүгт олон улсын байр сууриа бэхжүүлэх ашиг сонирхлоос нь юуны өмнө үүдэлтэйгээр энэ тухайд зарчмын хувьд өөр бодлого баримталж байв. ЗСБНХОУ-ын Гадаад хэргийн ардын комиссарын газраас Монголын Засгийн газарт ирүүлсэн нот бичигтээ: “Оросын хөдөмөрчин олон түмэн, түүний хүсэл зоригийг илэрхийлэгч ажилчин-тариачны Засгийн газар Монголын ардын хувьсгалт засгийн газар байгуулагдсанд баяр хүргэж байна” хэмээжээ. Зөвлөлт засаг ийнхүү манай тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх төдийгүй аюулгүй байдлыг хангахад тусалж, дипломат шугамаар дэмжлэг үзүүлж байлаа.

1921 оны 10 дугаар сарын 26-наас Москва хотноо явагдсан албан ёсны хэлэлцээний дүнд “Монгол, Орос хоёрын хоорондох найрамдлын барилдлагааг байгуулах тухай Монголын Ардын засгийн газар ба Зөвлөлийн засагт Орос Улсын Засгийн газрын хэлэлцэн тогтоосон Гэрээ бичиг” буюу өнөөгийн хэллэгээр Монгол улс, Орос улсын найрсаг харилцааны тухай хэлэлцээрийг байгуулжээ. Энэхүү баримт бичгийн улс төрийн гол агуулга нь Монголын Ардын засгийн газрыг хүлээн зөвшөөрсөн явдал байв. Монгол, Оросын 1921 оны эл хэлэлцээр нь Монголын шинэ үеийн түүхэнд нөлөө бүхий гүрэнтэй эрх тэгш байгуулсан анхны гэрээ юм. */Хоёр талаас гарын үсэг зурагсдын зэрэг зиндааг хөндөн үзсэн зүйл түүхчдийн дунд байдаг ч ямар боловч Засгийн газар хоорондын хэлэлцээр байсныг гол болгон үзүүштэй/. Түүнчилэн талууд дипломат болон консулын төлөөлөгчдөө солилцохоор заасан нь чухамдаа дипломат харилцаа тогтоосон хэрэг мөн. Эдийн засаг, худалдааны болон эрх зүйн харилцаанд харилцан найрсаг хандах зарчмыг баримтлах, нөгөө талд дайсагнагч байгууллагын үйл ажиллагааг нутаг дээрээ үс зөвшөөрөх заалтууд орсон байна. Мөн хоёр улсын хоорондын хилийг тогтоох тусгайлсан комиссыг цаашид томилон ажиллуулахаар тохирчээ. Хэлэлцээрийн зарим заалтыг тодотгосон 2 Хавсралт протоколыг хамтад нь байгуулсан байна. Түүний нэгд нь “Монголын талд тулган хүлээлгэсэн шинжтэй концессуудаар илэрхийлэгдэх эдийн засгийн хөнгөлөлтүүдээс” оросын тал татгалзахаа илэрхийлсэн ажээ.*

Монгол Улс дотооддоо болон гадаад орчинд бэхжихэд энэхүү хэлэлцээр чухал үр нөлөө үзүүлж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжлийн суурь дэвсгэр болж өгсөн юм. Үүнд үндэслэн Монголын хувьд нэн чухал, цаашдын хөгжлийн шинж төлвийг тодорхойлсон гэрээ, хэлэлцээрүүд байгуулагдсан билээ.

Арай хожуу, 1924 оны 5 дугаар сарын 31-нд байгуулсан ЗХУ, Хятадын гэрээнд “Гадаад Монгол /ө.х. Монгол Улс/ нь Бүгд Найрамдах Хятад Улсын бүрэлдүүн хэсэг мөн” хэмээн заасныг дээр яригдсан зүйлтэй уялдуулан үзвэл наад зах нь хачирхалтай санагдах. */Үүнийг барьж авч “ноцолдох” хүмүүс ч байх/. Асуудлыг ийн “шийдсэн” нь*

Зөвлөлтийн талаас “тооцоотойгоор тал зассан” /конъюнктурный/ алхам байсан юм болов уу хэмээн төсөөлөгддөг. ЗХУ-ыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлэхэд тэр гэрээ зайлшгүй хэрэгтэй байсан гэж түүхчид нэг бус удаа тэмдэглэсэн нь бий. Чухам Зөвлөлт, Хятадын гэрээнд гарын үсэг зурсны дараагаас Монголд бүгд найрамдах засаглалыг тогтоох санаачилга идэвхжиж, яравчлан хэрэгжсэн нь зүгээр нэг тохиолдол биш байж болох юм. Зөвлөлтийн зөвлөгч наргүйгээр эл санаачилга хэрэгжчихээгүй байх. Гадаад хэргийн ардын комиссарын орлогч Л.М.Караханаас Хятадын засгийн газарт 1925 оны 3 дугаар сард өгсөн нот бичигт: “Хятадын засгийн газар монголын ард түмэнтэй энх тайван хэлэлцээний замаар ах дүү /хятад, монгол/ хоёр ард түмний харилцааны асуудлуудыг шийдэх боломжийг алдахгүй хэмээн найдаж” буйгаа илэрхийлэн, “ЗХУ-ын Засгийн газар хятад-монголын харилцааны асуудал бүхэлдээ гагцхүү энэ хоёр ард түмний хэрэг хэмээн үзэхийн хамт хоёр ард түмний хоорондын хамтын амьдралын ах дүүгийн барилдлага нь тэдний үндэсний зорилго эрмэлзэлд нийцсэн, шударга байдлаар тогтоосон байваас баяртай байх болно” хэмээсэн нь Зөвлөлтийн засгийн газрын дээрх “хачирхалтай” хандлагыг нотолж буй нэг баримт гэж үзэж болно.

Монгол, Оросын найрсаг харилцааны тухай 1921 оны хэлэлцээр олон улс-эрх зүйн тогтолцоонд Монгол Улсын эзлэх байр суурийг бэхжүүлэх урт хугацааны үйл явцын эхлэл болжээ хэмээн бүхэлд нь дүгнэж болно. БНХАУ /1949 он/ бусад социалист орнууд /1948-1950 онд/, шинээр тусгаар тогтносон орнууд /1950-иад оноос/, хөгжингүй орнуудтай /1960-аад оноос эхлэн/ дипломат харилцаа тогтоосноор Монгол Улсын олон улсын байр суурь улам бэхжиж ирлээ. Энэ жил 100 жилийн ойгоо тэмдэглэж байгаа манай дипломат алба энэхүү нөр их хүчин чармайлтын бүхий л үе шатанд жинтэй хувь нэмрээ оруулж ирсэн билээ.

Өнөө Монгол Улс олон улсын харилцаанд идэвхтэй оролцож, дэлхийн 154 улстай дипломат харилцаа тогтоон, НҮБ болон олон улсын бусад байгууллагад гишүүн, олон талт гэрээ хэлэлцээрүүдэд оролцогч болж байна. Энэ бүхэн Монголын ард түмний эрх сайн сайхан, энх тайван, аюулгүй байдлын ашиг тусын тулд дэлхийн улс түмэнтэй харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх бодит тулгуур болж байна.